

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ОНОЛ, ЧИГ ХАНДЛАГА

STRATEGIC MANAGEMENT THEORY AND APPROACH



Дотоод Аюулгүй Байдлын Академи

Э.Мандах

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хошууч

Б.Батзаяа

8021 дүгээр дамжааны суралцагч цагдаагийн ахмад

E. Mandah

University of Internal Affairs, Academy of Management 8021st year student, Police major

B.Batzaya

8021st year student, Police Captain

*Хариуцлагатай зохиогч: Zaya@gmail.com

Хураангуй: Өнөөгийн нийгэмд стратеги төлөвлөгөөг байгууллагууд, улс орнууд өөртөө давуу талыг бий болгохыг зорин, бодлогын түвшинд ашиглаж байна. Энэ үед байгууллагын голлох шатны ажлын төлөвлөгөө эсхүл үндсэн стратегийн хүрээнд явагдах компани ажлууд нь томоохон байр суурийг эзэлж, үйл ажиллагаагаараа илэрхийлж байдаг. Судлаач Карл вон Клаусвитце стратегийг “дайны төлөвлөгөө боловсруулах, дайралтад бэлтгэх, зохион байгуулах, ажиллагаа бүрийг тусгайлан шийдэх үйл явц” гэж тодорхойлсон ч түүхч Эдуарт Мыд Ийрлээ улс орнуудын хооронд уралдаж орчин цагт тохируулж стратегийг түүнчлэн өргөн хүрээнд авч үзэн “нэг улсын эсвэл, холбоотон улсууд тус бүрийн ашиг сонирхлыг төлөвшүүлэн хамгаалах, дэмжих үүднээс тэдгээрийн нөөц баялгийг оновчтой удирдах ухаан” гэх байдлаар онолын хувьд тодорхойлж байжээ.

Бизнесийн салбар тэр дундаа тухайн үеийн цэрэг дайны зүйрлэлд хэзээнээс дуртай ба стратеги гэх ойлголтыг хамгийн Түрүүнд авч хэрэгжүүлсэн нь огт гайхах зүйл биш бөгөөд стратеги бол тэдний хувьд ашиг сонирхлоо дэмжих, хамгаалахын тулд өөрт байгаа бүхий л нөхцөл боломжоо (*хүн болон материаллаг зүйл санхүүгийн нөөц боломж*)-ийг зөв удирдах ухаан юм (Андрес., 1971). Компаний стратеги ямар нөхцөл байдалд байгаа (*гадаад орчны боломж болон аюул*), хэрхэн, юуг хийж чадах (*бизнесийн давуу ба сул тал*)-аас хамаарна гэх ойлголтыг өнөө үе хүртэл зөвхөн бизнесийн салбар бусад төрийн байгууллагууд ч ашиглаж стратеги төлөвлөгөөний суурь судалгаа болгож ашиглаж байна.

Стратеги нь нэг талаас тодорхойгүй нөхцөл байдлын үед өмнөө тавьсан зорилгодоо хүрэхын тулд дунд болон урт хугацааны ерөнхий төлөвлөгөө гэдэг утгаарч тайлбарлагдана. Тодорхой аж ахуйн нэгж байгууллага өргөжин тэлэх үедээ хэтийн чиглэлтэй удирдах үйл ажиллагаа зайлшгүй шаардлага бий болдог. Мөн хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварыг удаан хугацаанд хадгалахад зорилтот бодлого зайлшгүй хэрэгтэй гэх мэт нөхцөл байдлаас шалтгаалан стратегийн удирдлага буй болсон гэж үздэг.

Энэхүү сэдвийн хүрээнд түүхэн хугацаанд дэлхий дахинд эрдэмтэн, судлаачид стратегийн удирдлагын онолыг судалж, цаашдын чиг хандлагыг ямар тодорхойлж түүний чиг хандлага ямар байсан талаар судлаж эрдэмтэн судлаачдын тал бүрээс тодорхойлсон онол, хандлагыг судалж орчин цагийн байгууллагын үйл ажиллагааны стратеги ямар байдлаар явах нь оновчтой байх талаар дүгнэлтэд хүрэхийг зорьлоо.

Abstract: In contemporary society, strategic planning is widely employed by organizations and nations as a key policy tool to create competitive advantages. Within this context, an organization's primary operational plans or major initiatives implemented under its core strategy hold significant importance and clearly reflect its activities. Researcher Carl von Clausewitz defined strategy as “the process of developing war plans, preparing for offensive actions, organizing and managing all military operations.” Meanwhile, historian Eduard Meade Earle expanded this concept in a modern context and argued that strategy should be understood



ХҮҮЛЬ САХИУЛАХ УДИРДЛАГА

more broadly as “the art of mobilizing and allocating the resources of a nation, or a coalition of nations, to safeguard, promote, and advance their respective interests.”

The business sector has historically favored military analogies, and it is therefore unsurprising that businesses were among the first to apply the concept of strategy. For firms, strategy represents the intellectual capacity to effectively manage all available resources—human, financial, and material—to protect and advance their interests (Andres, 1971). The notion that a company’s strategy depends on its external context (opportunities and threats) and internal capabilities (strengths and weaknesses) remains foundational, and today, this approach is also applied not only in business but across governmental institutions as a basis for strategic planning.

This study aims to analyze global scholarly perspectives on strategic management theory from a historical context, examine its developmental trends, and identify the most effective strategic approach for modern organizations by evaluating diverse theoretical viewpoints and historical evolution of strategic thought.

Түлхүүр үгс : Стратеги, удирдлага, зорилго, зарчим, хандлага.

Key words : Strategy, leadership, goals, principles and attitudes.

Оршил

Байгууллагын амжилтад хүрэх түлхүүр бол сайн стратеги юм. Стратегийг зөв боловсруулнаа гэдэг нь “ажлаа зөв сонгож хийх” тухай ойлголт бөгөөд дээд шатны буюу байгууллагын менежерийн түвшинд хийх ажиллагаа юм. Харин хэрэгжүүлэлт бол “зөв хийх” тухай асуудал. Стратеги хэрэгжихгүй бол үнэ цэнэгүй зүйл болон хувирч үүнд дээд, дунд шатны менежер оролцогчид онцгой анхаарал хандуулах шаардлага үүсдэг тул үүнийг ямар нэгэн эрсдэлгүй хийх чухал.

Удирдахуйн ухааны онолын бүтээлүүдээс дүгнэхэд стратегийн ач холбогдлыг өргөн хүрээнд авч үздэг хэр нь хэрэгжилтийн асуудлыг төдийлөн хөнддөггүй байх нь түгээмэл. Ингэхээр стратеги боловсруулах, хэрэгжүүлэх тухай нь хоорондоо нягт уялдаа холбоотой ба эдгээр ойлголтыг нэг нэгнээс нь салгах боломжгүй.

Аливаа улс орнуудын хөгжил дэвшлийн гарц нь дан ганц мэдээлэл, технологи, бус харин нарийн стратегийн удирдлагатай холбоотой гэж үзэх болсон. Харин байгууллагыг сайн менежер л үр дүн, үр ашигтай удирдаж чадах тул байгууллагын удирдлагын ур чадварыг хөгжүүлж, бэхжүүлэх талаар анхаарч сургалт сурталчилгааны үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах нь илүү үр дүнтэй юм.

Стратегийн удирдлагын талаарх хууль эрх зүйн онол, түүний мөн чанар, хэрэгцээ, шаардлага

Стратеги – “strategies” гэх грек үгээс үүсэлтэй ба цэргийн жанжны ур ухаан гэж тайлбарласан байдаг. Хамгийн анх “генералын ур ухаан” гэсэн утга бүхий байсан ба стратеги нь генерал хүн ялалт байгуулахын тулд цэргийн хүчээ зөв оновчтой хохиион байгуулах талаар боловсруулсан төлөвлөгөө юм (Өлзийсайхан, 2019) гэх утгаар эх сурвалжуудад тэмдэглэгдсэн байдаг. Тэртээ 2500 жилийн өмнө эртний Хятад улсад Зүнх Ү хэмээх жанжины тууривсан “Сүнзын дайтах урлаг” гэх номонд цэргийн дайтах стратеги, тактийн талаар дурдсан байдаг.

Стратегийн удирдлагыг үндэслэгчдийн нэг “Boston Consulting group”-ийн үүсгэн байгуулагч ноён Брюс Хэндэрсон нь стратеги, өрсөлдөөний давуу тал гэх тусдаа ойлголтыг анх холбон тайлбарласан. Тэр “Стратеги бол компанийг өрсөлдөөний давуу тал бий болгох, сайжруулах боломжоо гаргах эрэл хайгуул” гэх утгаар тодорхойлжээ. Түүний үзсэнээр “Адил төрлийн бизнес эрхэлж байгаа өрсөлдөгчид зэрэгцэн орших боломжгүй ба аливаа бизнес бусдаас ялгарч байж оршин тогтоно. Бизнесийн үйл ажиллагаа тус бүр өөрийн онцлог шинжтэй ба түүнээс салбарлан гарсан өвөрмөц давуу талтай байх ёстой” гэж үзжээ. Үүнээс дүгнэхэд өрсөлдөөний стратеги “бусдаас



өөр байх”, гэхдээ “өөр байна” гэдэг нь зарим талаараа шууд өрсөлдөөний “давуу талтай, амжилттай байна” гэсэн утгаар тэр бүр тайлбарлагдахгүй. Тухайлбал, пуужин шиг хүчирхэг хөдөлгүүр бүхий автомашин бусдаас “ялгарах” хэдий ч хэрэглэгчдийг улам илүү татах нь юу л бол. Харин гибридийн буюу шатахуун, цахилгаан хосолсон автомашин түлш хэмнэж, орчны бохирдолтыг бууруулах учраас хэрэглэгчдэд илүү үнэ цэнэ өгөх нь тухайн ойлголтоор тайлбарлагдаж болох юм.

Стратегийн удирдлага нь аж ахуйн нэгж байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрэх боломж бий болгох чадварыг хөгжүүлэх үйл явц. Мөн тодорхой асуудлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн төлөвт авч үзэж хэтийн чиг хандлагыг тодорхойлохын тулд шинжлэх ухааны аргуудад тулгуурладаг.

Байгууллагын стратеги, түүний удирдлагын талаар дэлхийн өнцөг булан бүрийн тодорхой он цагийн эрдэмтэн, судлаачид судлаж өөр өөрийн байр сууринаас тайлбарлаж тэдгээрээс дурдвал:

➤ Америкийн нэгдсэн улсын Харвардын бизнесийн сургуулийн, Жон Хопкинсийн их сургуулийн эрдэмтэн профессор Альфред Д.Д.Чандлер “Стратеги гэдэг нь байгууллагын он цагийн урт хугацааны үндсэн зорилгыг тодорхойлох, үйл ажиллагааны чиглэлийг бататгах, тухайн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг хуваарилах явдал”; (Chandler, n.d.)

➤ АНУ-ын Харвард их сургуулийн Бизнесийн сургууль болон Бишопп Уильям Лауренсийн их сургуулийн профессор Майкл Портер Жр нь: “Стратеги гэдэг нь бизнест хэрхэн өрсөлдөх гэж байгаа түүний зорилго ямар байх, тухайн зорилгыг хэрэгжүүлэхэд ямар бодлого шаардлагатай болох тухай томъёолол ба тэрхүү зорилгодоо тууштай хүрэхын тулд ашиглах хэрэглэх, арга хэрэгсэл”; (Porter, n.d.)

➤ АНУ-ын Мемфисийн их сургуулийн профессор Питер Райтес (Өлзийсайхан Б., 2019, хууд. 11) “Стратеги нь байгууллагын эрхэм зорилго, зорилгод хүрэхээр дээд түвшний менежер

тэдгээрийн боловсруулсан төлөвлөгөө бол харин стратегийн удирдлага нь гадаад, дотоод орчныг шинжлэх, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлох, стратегийн томъёолол, стратегийн хэрэгжилт гэсэн салшгүй гурван үйл явцын нэгдэл” гэх зэргээр тодорхойлсон байна.

➤ Канадын МакГилл-ийн их сургуулийн профессор Хенрик Минцберг 1998 онд стратегийн талаар дараах тодорхойлолтуудыг анх удаа тайлбарласан. (Mintzberg., 1998)

Түүнчлэн стратеги түүний удирдлагын талаар олон улсын эрдэмтэн, судлаач нараас гадна манай улсын зарим эрдэмтэд ч судлаж өөр өөрийн гэсэн байр сууриа илэрхийлж он цагийн үеийн дарааллаар уран бүтээлүүд туурьвисаар ирсэн байна. Тухайлбал Ү.Чимэд, Т.Дорж нар “Менежмент” гэх бүтээлдээ:

“Стратеги нь зорилго, зорилтуудад чиглэсэн иж бүрдэлт төлөвлөгөө байдаг бол стратегийн удирдлага нь байгууллага урт хугацаанд оршин тогтнож тавьсан зорилгодоо хүрэх боломж өгөхөд чиглэсэн удирдлага” гэж тайлбарлажээ. (Т. Дорж, Ү. Чимэд, 2000, хууд. 15)

Судлаач Д.Лхаашид “Стратеги нь орчны хувьсал, өөрчлөлтөд зохицуулах, байгууллагынхаа холч давуу талыг хадгалах хамгийн гол нэгдмэл, иж бүрэн, цогцолбор зорилго байдаг бол стратегийн удирдлага нь онол арга зүйд тулгуурлан байгууллагын үйл ажиллагааг хөгжлийн илүү дээд түвшинд хүргэхэд чиглэсэн зорилтуудыг агуулсан зангилаа буюу шийдвэр гаргах үйл явц” гэж тайлбарлажээ. (Д. Лхаашид, Р. Бадралмаа, 1996)

Эдгээрээс дүгнэхэд стратеги нь товчхондоо “байгууллагыг амжилттай ил тод ажиллах, богино хугацаанд бага, хямд төсөр зардлаар өмнө тавьсан зорилго, зорилтдоо хүрэх арга зам буюу “амжилтанд хүрэх суурь төлөвлөгөө” юм. Өөрөөр хэлбэл хэн, юуг хэрхэн хийх, ямар болгох, хамгийн чухал нь “зорилгодоо яаж хүрэхээ ойлгох” юм гэж тодорхойлсон байдаг.

Аливаа жижиг, том аль нэг байгууллагын бүтцийн нэгжүүдэд алсын хараа, цаашдын зорилгоо тодорхойлсон стратеги байж болох боловч эдгээр нэгж




ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠤᠢᠭᠣᠯᠠᠭᠤᠨ ᠰᠤᠷᠢᠭᠡᠭᠢᠨ ᠠᠵᠤᠨ ᠠᠭᠤᠨ ᠠᠭᠤᠨ

бүрийн (*тасаг, хэлтэс, газар, алба зэргээр шаталсан хэлбэртэй бүтэц бүхий байгууллага*) стратеги нь байгууллагын ерөнхий стратеги зорилготой уялдах ёстой. Стратеги болон тактикийн төлөвлөлтөд байдаг ялгаа нь байгууллагын цаашдын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг илэрхийлж байвал энэ нь стратеги төлөвлөлт болно.

Зөв стратегийг чадварлагаар үр дүнтэй хэрэгжүүлвэл тодорхой аж ахуйн нэгж байгууллагын зорилго, чиглэлийг бүх

түвшний менежер, хамт олон тодорхой ойлгож, улмаар байгууллагаа амжилтад хүргэхийн тулд “юуг хэрхэн хийх хэрэгтэй вэ” гэдэг нь ойлгомжтой болж тэдгээрийн шалтгаан нөхцлийг олдог юм. Харин тодорхой стратеги байхгүйгээр байгууллага “жолоочгүй жолоодлогогүй машин” шиг ажиллаж боломж, хүндрэл, бэрхшээл гарах бүрт зорилго, чиглэлээ өөрчилж чиг шугамаа алдаж, өдөр хоногийг үр дүнгүй аргацсаар өнгөрүүлнэ.



Хүснэгт 1. Стратегийн удирдлагын зарчим

Байгууллагын стратегийн удирдлага, хандлага:

Байгууллагын стратегийн удирдлагын талаар авч үзэхийн тулд эхлээд “байгууллага” (Баярсайхан, 2011, 108 дах тал) гэсэн нэр томъёоноос эхлэх нь зүйтэй.

Монгол хэлний толь бичигт: Байгууллага нь– 1. Албан газар: Захиргааны нэгж байгууллага (*засаг, захиргааны үйл ажиллагаа эрхэлдэг газар*), 2. Төрийн байгууллага (*төрийн захиргааны үйл ажиллагаа эрхэлдэг алба*), 3. Албан байгууллага (*албан газар, байгууллага*) гэж тайлбарласан байдаг.

Менежментийн шинжлэх ухааны суурь судалгааны гол объект болох “байгууллага” нь тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд үйл ажиллагаагаа нарийн зохион байгуулдаг хэлбэр бүхий цогц систем юм. Товчхондоо “байгууллага” нь урдаа тавьсан **эрхэм зорилго, зорилт** тухайн байгууллагын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл ба соёлын өв, тухайн байгууллагын **зорилго** нь түүний хүрэхээр тэмүүлж байгаа байгууллагын **зорилт** нь эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тодорхой цаг хугацааг үе шаттайгаар хэрэгжүүлж гүйцэтгэхээр төлөвлөсөн

ажлаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд тодорхой үйл ажиллагааг ухамсартайгаар зохицуулан, түүндээ хүрэх чин эрмэлзлэл бүхий бүлэг хүмүүсийн нийлмэл нэгдэл юм гэж тодорхойлсон байдаг.

Тэгвэл аливаа “байгууллага” нь эгэл жирийн нэгдмэл ашиг сонмирхолгүй бүлэг хүмүүсээс ялгагдахын тулд дараах үндсэн шалгууруудаар хэмжигдэж тодорхойлогдоно. Үүнд:

- Хоёр ба түүнээс дээш ажилтан алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байх;
- Бүлгийн нийт гишүүд өмнөө тавьсан нийтлэг зорилго, зорилтыг хүлээн зөвшөөрсөн, түүндээ хүрэх хүсэл эрмэлзлэлтэй байх;
- Нэгдмэл нэг цогц удирдлагын дор үйл ажиллагаа явуулах;
- Байнгын давтамжтай тасралтгүй үйл ажиллагаа явуулах зэрэг үндсэн бусад шаардлага шалгуурыг хангасан байх ёстой юм.

Стратеги нь байгууллагын эрхэм зорилгоос урган гардаг. Байгууллагын стратеги боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь өргөн хүрээтэй, цаг хугацаа шаардсан бөгөөд байгууллагын онолоор орцыг гарц болгон хувиргах нэг төрлийн



процесс гэж үзэж болно. Энэ үйл явцад дээд шатны удирдлага эрхэм зорилгын хүрээнд хэрэгжиж болохуйц зорилго, зорилтуудыг тодорхойлж, тэдгээрийг хангах нөхцөлийг нарийвчлан судалдаг. Мэдээж эдгээр зорилтууд нь хийсвэр сэтгэлгээ эсвэл хоосон мөрөөдөл биш бөгөөд биелэгдэхүйц, бодит нөхцөлд тулгуурласан ирээдүйн чиг баримжаа байх шаардлагатай.

Стратеги боловсруулах үйл явц нь өргөн далайцтай, цаг хугацаа шаардсан, судалгаа, дүн шинжилгээнд үндэслэсэн үйл ажиллагаа бөгөөд байгууллага урт хугацаанд амжилттай ажиллахын тулд нэн

тэргүүнд тулгамдсан асуудлуудыг тодорхойлдог. Үүний тулд байгууллагын бүтцийн нэгжүүд, хэлтэс, тасаг, баг бүр эдгээр асуудлуудыг чиглэсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, түүн дээр үндэслэн стратегийн зорилго, чиглэлүүдийг тодорхойлдог.

Стратеги батлагдсан даруйд шууд хэрэгжихгүй бөгөөд цаг хугацаа, төсөв, санхүү, бусад нөөцийг шаардсан өргөн хүрээний үйл ажиллагаа тул хэд хэдэн үе шат дамжин хэрэгждэг. (Оргилон, 2017, тал 10)

1. Стратегийн шинжилгээ :

- a) Макро орчны шинжилгээ
- b) Салбарын болон орчны шинжилгээ
- c) Нөхцөл байдлын шинжилгээ
- d) Эрхэм зорилго, зорилго, зорилтууд

2. Стратегийн томьёолол

- a) Бүтцийн нэгжүүдийн стратеги
- b) Байгууллагын стратеги
- c) Салбарын стратеги

3. Стратегийн хэрэгжүүлэлт

- a) Гүйцэтгэлийн хяналт, түүний төрлүүд систем
- b) Стратегийн хяналтын систем
- c) Үйл ажиллагааны мэдээллийн систем

4. Стратегийн хяналт

- a) Бүтэц, зохион байгуулалт
- b) Стратегийн манлайлал

Байгууллагын стратегийн хэрэгжих үе шат

Хөгжлийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа анх бизнесийн салбарт үүсэн хөгжиж, удирдлагын шинжлэх ухаанд стратегийн удирдлага гэсэн шинэ чиглэл бий болгоход чухал түлхэц болсон. Энэ талаар олон эрдэмтэн, судлаачид нарийн судалгаа хийж, шинжлэх ухаанд бодит хувь нэмрээ оруулсаар байна. Үүний нэгэн адил төрийн байгууллагын стратеги нь төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн алба хаагчийн ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэх, байгууллагын хөгжлийг шинэ шатанд гаргах, шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зэрэг цогц бодлогын хүрээнд яригддаг. Иймээс төрийн байгууллагын стратеги хөгжлийн хэрэгцээ, цаг үеийн шаардлагад нийцсэн өргөн агуулгатай болох нь чухал юм.

Монгол Улс төрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хэрэгцээ

шаардлагын үүднээс стратеги хөгжлийг үндэсний эрх зүйн зохицуулалтаар хангаж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)–д:

- 53.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

- 53.2. Хуульд өөрөөр заагаагүй бол стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

Мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3-т дотоод аюулгүй байдлыг хангах талаар авч үзсэн бөгөөд хүний эрх, үндсэн хуульт байгууллагыг бататгах, хууль дээдлэх ёсыг сахиулах, төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг дээдлэх, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс гэж тодорхойлсон.



ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ
ᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ

Энэ хүрээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг нь:
- Иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг бүрдүүлж гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах;
- Гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, захиргааны дүрэм, журмыг сахиулах;
- Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт хор уршиг учруулж болзошгүй аюулыг арилгах, урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Үндэсний аюулгүй байдлын системийн хүрээнд цагдаагийн байгууллага нь дотоод аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хуулиар хүлээсэн чиг үүргээ оновчтой бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөц, техник технологийн дэвшилтэйгээр хэрэгжүүлэх ёстой. Ийм үйл ажиллагаа нь урт хугацааны стратеги, төлөвлөгөөнд тулгуурлаж явуулах шаардлагатай.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хууль-ын 16 дугаар зүйлд:
- 16.1. Засгийн газар цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны нөхцлийг санхүү, материал, техникээр хангана.
- 16.2. Засгийн газар цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг батална гэж заасан нь стратеги хөтөлбөрийн эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн байна. (Цагдаагийн албаны тухай хууль, 2017)

Стратегийн удирдлагын цаашдын хандлагыг авч үзвэл:

1. SWOT шинжилгээ нь байгууллагын дотоод болон гадаад орчны хүчин зүйлсийг нэгтгэн үнэлж, стратегийн тэргүүлэх чиглэл, шийдвэр гаргалт, байгууллагын дотоод хамтын ажиллагаа, харилцааг сайжруулахад чиглэдэг бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой стратегийн удирдлагын хэрэгсэл юм.

2. SMART шалгуурт тулгуурласан зорилт тодорхой, зорилгод төвлөрөх, байгууллагын стратегитэй уялдуулах, хариуцлагын тогтолцоог бий болгох,

инноваци, бүтээлч байдлыг дэмжих, нөөцийг оновчтой хуваарилах зэрэг стратегийн менежментийн үр дүнг сайжруулах боломжийг олгодог. Ийм зорилт бүрдүүлснээр байгууллага стратеги төлөвлөгөөгөө илүү үр өгөөжтэй хэрэгжүүлж, зорьсон үр дүнд хүрэх боломж нэмэгддэг.

3. Ажилтнуудын санал хүсэлт, санал асуулгыг тогтмол авах нь стратегийн хэрэгжилтийн үнэлгээг сайжруулж, шаардлагатай тохиолдолд стратегид түргэн шуурхай шинэчлэл хийх боломжийг бий болгодог. Мөн стратеги боловсруулахад ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх нь байгууллагын зорилгыг нийт ажилтнуудад уялдуулахад дэмжлэг болдог. Жишээ нь, AhaSlides зэрэг дижитал хэрэгслийг ашиглан санал хүсэлт цуглуулах, дүн шинжилгээ хийх нь илүү үр дүнтэй арга хэлбэр болдог.

4. Инноваци болон бүтээлч арга зүйг нэвтрүүлэх нь технологийн дэвшил хурдтай өөрчлөгдөж буй орчинд байгууллагыг давуу талтай байр сууринд байлгаж, стратегийн менежментийн төлөвлөлт болон хэрэгжилтийг сайжруулдаг. Өндөр технологийн программ хангамжийг удирдлагын үйл ажиллагаанд ашиглах нь гүйцэтгэлийг хянах, үнэлэх үйл явцыг оновчтой болгодог.

5. Хариуцлагын соёлыг төлөвшүүлэх нь стратеги хэрэгжилтийн амжилтад чухал үүрэг гүйцэтгэнэ. Стратегийн төлөвлөгөөнд оролцсон хувь нэмрийг үнэлэн ажилтнууд хариуцлага хүлээдэг тогтолцоог бүрдүүлэх нь үр дүнтэй хэрэгжилтийг хангах ба алдаа зөрчлийг цаг тухайд нь засах боломжийг бүрдүүлдэг.

6. Тодорхой, ил тод харилцаа холбоо нь стратеги амжилттай хэрэгжүүлэх үндэс бөгөөд удирдлагууд, менежерүүд болон ажилтнуудын хооронд мэдээллийг шуурхай, ойлгомжтой хүргэх шаардлагатай. Үүнд стратегийн зорилтууд, хэрэгжилтийн явц, үүрэг хариуцлагын талаар таниулга хийх, бүх ажилтан байгууллагын зорилго, зорилтыг ойлгох нөхцөлийг бүрдүүлэх зэрэг багтана.

7. Сургалт, чадавхижуулалтын тогтолцоог хөгжүүлэх нь байгууллагын стратегийг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадамжийг сайжруулах ач холбогдолтой. Хэлтэс, нэгжүүд хүний нөөцийн албатай хамтран ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах нь үр дүнтэй. Мөн AhaSlides зэрэг интерактив сургалтын хэрэгсэл ашиглах нь ажилтнуудын оролцоог дэмжиж, суралцах үйл явцыг илүү үр бүтээлтэй болгодог.

Дүгнэлт

Стратегийн удирдлагын мөн чанар, ач холбогдол, түүнийг хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөл, онолын үндсийг судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг гаргав.

1. Стратеги нь байгууллагын зорилго, зорилтуудад хүрэхэд чиглэсэн иж бүрэн төлөвлөлт бөгөөд стратегийн удирдлага нь байгууллагын урт хугацааны тогтвортой хөгжил, өрсөлдөх чадвар, оршин тогтнох чадварыг хангахад төвлөрдөг удирдлагын аргачлал юм. Стратеги боловсруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь салангид бус, харилцан уялдаа бүхий тасралтгүй процесс бөгөөд нэг нь нөгөөгүйгээр бүрэн дүүрэн биелэлээ олохгүй.

2. Төрийн байгууллагууд стратеги боловсруулах нийтлэг загвар, арга зүйн дагуу ажиллах шаардлагатай бөгөөд энэхүү загварыг бодит үйл ажиллагаандаа хэвшүүлэн хэрэглэх нь үр дүнтэй менежментэд чухал нөлөө үзүүлнэ.

3. Стратегийн баримт бичиг батлагдсанаар тэр даруй хэрэгждэггүй ба хэрэгжилтийн төлөвлөлт, санхүүжилт, хүний нөөц, хугацааны зохион байгуулалт зэрэг олон хүчин зүйлсээс хамааран шат дараатайгаар хэрэгждэг өргөн хүрээний үйл явц болохыг тодорхойлов.

4. Төрийн байгууллагын стратеги төлөвлөгөө нь үндсэн зарчим, үнэт зүйлс, урт хугацааны зорилцуулах чиглэлийг тодорхойлсон, нарийн боловсруулалт шаардсан баримт бичиг бөгөөд институцийн үйл ажиллагааг системтэй удирдах хэрэгсэл юм.

5. Төрийн байгууллагууд дотоод болон гадаад орчны шинжилгээг шинжлэх

ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлж, түүн дээр үндэслэн зорилго, зорилтуудаа тодорхойлсноор байгууллагын хөгжлийн стратегийг илүү бодит, хэрэгжихүйц байдлаар боловсруулах боломжтой гэж үзэв.

6. Стратегийн удирдлага нь байгууллагын урт хугацааны зорилго, хөгжлийн чиг баримжааг тодорхойлж, дотоод нөөц ба гадаад орчны өөрчлөлтөд уялдуулан тогтвортой, үр ашигтай үйл ажиллагааг хангах үндсэн механизм юм.

7. Төрийн байгууллагын хувьд стратегийн төлөвлөлт нь хууль, хөгжлийн бодлоготой нийцсэн, судалгаа-шинжилгээнд тулгуурласан, шат дараалалтай хэрэгждэг тасралтгүй процесс бөгөөд нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх гол хэрэгсэл болдог.

Эдгээрээс дүгнэхэд, Монгол Улсад төрийн байгууллагууд стратегийн удирдлагын тогтолцоог эрх зүйн үндэслэлтэйгээр бүрдүүлээд байна. Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 53.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 36 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ыг баталсан. Энэхүү журамд төрийн болон нутгийн удирдлагын байгууллагууд стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, бүсчилсэн хөгжлийн бодлого, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан бөгөөд төрийн байгууллагууд стратегийн удирдлагыг шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн болохыг харуулж байна.

Эх сурвалжийн жагсаалт:

Chandler, A. D. (n.d.). *Strategy and structure*. http://ecsocman.hse.ru/data/175/631/1219/Chandler_mem.pdf

Mintzberg, H. (1998). *Wikipedia*.

https://ru.wikipedia.org/wiki/Минцберг,_Генри





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠳᠠᠭ᠎ᠠ

Porter, M. E. (n.d.). *Wikipedia*.

<https://mn.wikipedia.org>

Андрес., К. (1971). *The concept of corporate strategy*.

Баярсайхан, Б. (2011). *Монгол хэлний тайлбар толь*.

Д. Лхаашид, Р. Бадралмаа. (1996). *Стратегийн удирдлага*.

Оргилон, Д. (2017). *Стратегийн удирдлага*.

Өлзийсайхан, Б. (2019). *Стратегийн удирдлага*.

Өлзийсайхан, Б. (2019). *Стратегийн удирдлага*.

Т. Дорж, Ү. Чимэд. (2000). *Менежмент*.
хууль, Т. а. (2017). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*.

<https://www.legalinfo.mn/mn/detail/13025>

Цагдаагийн албаны тухай хууль. (2017).
Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

<https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74>